



"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2020. 12. 10 № 07/5974
танай _____ -ны № _____ -т

Тушаал хүргүүлэх тухай

"Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2020 оны А/225, А-379 дүгээр тушаалын хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

"Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-д хот хооронд тээвэрлэхээр бүртгэгдсэн мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн мэдээлэлд үндэслэн тээвэрлэлтийг үр ашигтай зохион байгуулж тухай бүр зөвшөөрөл олгох арга хэмжээ авч ажиллана.

Хавсралт: 7 хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА

Ё.ЖАРГАЛСАЙХАН



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/2020/15, А-379

Улаанбаатар
хот

Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн,
өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 194 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 142 дугаар тушаалаар баталсан "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг "Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-ийг ашиглан, халдвар хамгааллын дэглэмд нийцүүлэн хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

2. Тухайн сумаас хот хооронд тээвэрлэх болон тухайн сум руу татан авах мал, мах, хүнс, өвс тэжээл, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний мэдээллийг тухай бүр нэгтгэн аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Хот хооронд тээвэрлэх мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн талаарх мэдээллийг "Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-д тухай бүр бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт үүрэг болгосугай.


4. "Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-д хот хооронд тээвэрлэхээр бүртгэгдсэн мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн мэдээлэлд үндэслэн тээвэрлэлтийг үр ашигтай зохион байгуулж тухай бүр зөвшөөрөл олгохыг аймаг, нийслэлийн Автотээврийн төвд үүрэг болгосугай.

5. "Хот хооронд мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг тээвэрлэхэд баримтлах заавар"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Өвлийн идшийг тээвэрлэх заавар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. "Тээврийн удирдлагын нэгдсэн систем"-ийг ашиглах заавар, зөвлөмжийг нийтэд мэдээлэх, системээс гарах статистик мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг ханган холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргэж ажиллахыг Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Д.Наранпүрэвт зөвлөсүгэй.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нарт үүрэг болгосугай.





ХОТ ХООРОНД МАЛ, МАХ, ХҮНС, ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН, ӨВС ТЭЖЭЭЛИЙГ ТЭЭВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЗААВАР

Зорилго:

Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хот хооронд мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийн тээвэрлэлтийг үр ашигтай, найдвартай зохион байгуулах

Ачаа илгээх, тээвэрлэх:

1. Сумын Засаг даргын тамгын газар нь сумаас болон сум руу мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээл тээвэрлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж хүсэлтийг нэгдүгээр хүснэгтэнд заасны дагуу нэгтгэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт тухай бүр цахимаар хүргүүлнэ.
2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумаас ирсэн мэдээллийг нэгтгэн "Тээврийн удирдлагын нэгдсэн систем" /www.teeverzuuch.mn/-д оруулна.
3. Аймгийн Автотээврийн төв нь ачаа тээвэрлэлтийг баталгаажуулж, тээвэрлэгчид QR код олгон сумын ачаа илгээгч, тээвэрлэгчид мэдээллийг шуурхай хүргэнэ.
4. Харин аймгийн төвөөс ачаа илгээх, тээвэрлэх тохиолдолд www.teeverzuuch.mn цахим хаягаар ирүүлсэн илгээгч болон тээвэрлэгчийн хүсэлтийг аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Автотээврийн төв тус тус хянан баталгаажуулж, системд нэвтрэх эрх олгоно.
5. Аймаг, нийслэлийн Автотээврийн төв нь тээврийг зохион байгуулах арга хэмжээг авч, тээвэрлэгчид QR кодыг тухай бүр олгоно.
6. Аймгийн Автотээврийн төв нь мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэхэд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавина.
7. Хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-ын 6-д заасныг мөрдөж ажиллана.

Нэгдүгээр хүснэгт


СУМААС ХОТ ХООРОНД ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ТУХАЙН СУМ РУУ ТАТАН АВАХ МАЛ, МАХ, ХҮНС, ӨВС ТЭЖЭЭЛ, ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Ачаа илгээгчийн мэдээлэл*	Ачааны төрөл	Ачааны хэмжээ	Мал эмнэлгийн гэрчилгээний дугаар**	Ачаа илгээх байршил	Ачаа илгээх хугацаа	Ачаа хүлээн авах байршил	Ачаа хүлээн авах хугацаа	Ачаа илгээгчийн цахим хаяг	Ачаа илгээгчийн утасны дугаар

202... оны ... сарын ...-ны өдөр

гэн бол иргэний овог, нэрийг, байгууллага бол байгууллагын нэрийг бичнэ.
ал, мах тээвэрлүүлэх тохиолдолд гэрчилгээний дугаар бичнэ.

ээлэл гаргасан:



ӨВЛИЙН ИДШИЙГ ТЭЭВЭРЛЭХ ЗААВАР

Нэг. Зорилго:

Хөдөө орон нутгаас хот суурин газрын айл өрхийн хэрэгцээнд нийлүүлэх өвлийн идшийг тээвэрлэх үйл ажиллагааг зохицуулах

Хоёр. Хугацаа:

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал

Гурав. Өвлийн идэшний тээвэрлэлтийг зохион байгуулах байгууллагын эрх, үүрэг

- 3.1. Сумын Засаг даргын тамгын газар, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь өвлийн идшийг төвлөрүүлэн хүлээн авах халдвар хамгааллын шаардлага хангасан цэгийг тогтооно.
- 3.2. Тогтоосон цэгт өвлийн идшийг хүлээн хуваарийг баталж, нийтэд мэдээлнэ.
- 3.3. Өвлийн идшийг битүүмжлэл сайтай зориулалтын сав, баглаа боодолд савлаж, ачаа хүлээн авагчийн хаяг /илгээгч болон хүлээн авагчийн нэр, утасны дугаар/-ыг гаргацтай тод харагдахаар байршуулж бэлтгэсэн байдлаар хүлээн авна.
- 3.4. Хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг ачаа хүлээн авах байршлаар нэгтгэн "Хот хооронд мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг тээвэрлэхэд баримтлах заавар"-ын дагуу "Тээврийн удирдлагын нэгдсэн систем" /www.teeverzuuch.mn/-д оруулна.
- 3.5. Аймгийн Автотээврийн төв, "Монгол шуудан" ХК "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-ын дагуу өвлийн идэшний тээвэрлэлтийг зохион байгуулна.
- 3.6. Өвлийн идшийг хүлээн авах, буулгах, бүртгэх, хаяглах, түр хадгалах үйл ажиллагаанд халдвар хамгаалал, халдваргүйтгэлийн дэглэмийг сайтар мөрдөж ажиллана.

Дөрөв. Өвлийн идшийг тээвэрлэх жолоочийн эрх, үүрэг

- 4.1. Тээвэрлэлт эхлэхээс өмнө коронавирусын шинжилгээнд хамрагдаж, халдваргүй болохоо баталгаажуулсан байна.
- 4.2. Өвлийн идэш тээвэрлэхэд "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам"-д заасан

- 4.3. Өвлийн идэшний сав, баглаа боодлын тоо ширхэг, бүрэн бүтэн байдлыг хариуцаж, илгээгч, хүлээн авагчийн мэдээллийг нягталж ачилт, тээвэрлэлтийг хийнэ.
- 4.4. Ачаа тээвэрлэх явцад тээврийн хэрэгсэлд эвдрэл гэмтэл, саатал гарсан тохиолдолд харьяалах цагдаагийн хэсэг, тасагт мэдэгдэнэ.

Тав. Өвлийн идшийг хүлээн авах, түгээх аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

- 5.1. “Улаанбаатар импекс” ХХК нь нийслэлийн Эмээлт, Шар хөтөл, Баруун туруун, Таван толгой, Өлзийт товчоогоор тээвэрлэн орж ирсэн өвлийн идшийг, “МБҮ трейд” ХХК нь Хэрлэн, Налайх дүүргийн 4 дүгээр зөрлөгөөр орж ирсэн өвлийн идшийг сав баглаа боодлын тоо ширхэг, бүрэн бүтэн байдалд хяналт тавин, илгээгч, хүлээн авагчийн мэдээллийг баримтжуулж хүлээж авна.
- 5.2. Ковид-19 цар тахлын халдварын тохиолдол бүртгэгдсэн аймаг, орон нутгаас ирсэн ачааг тусгай тэмдэглэл бүхий талбайд буулгаж 72 цаг хадгалж, халдваргүйтгэлийг хийнэ.
- 5.3. Зааврын 5.1-д заасан түр хадгалах агуулахад буулгасан өвлийн идшийг хүлээн авагчид хүргэж өгөх үйл ажиллагааг “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам”-ын дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, “Монгол шуудан” ХК зохион байгуулна.
- 5.4. Өвлийн идшийг буулгах, хураах, түр хадгалах, ачих, түгээн хүргэх үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэмийг нарийн чанд баримталж ажиллана.
- 5.5. Өвлийн идэшний тээвэр, түгээлтийг холбогдох төлбөр тооцоог цахим хэлбэрээр хийнэ.
- 5.6. Бусад томоохон хот суурин газарт өвлийн идшийг буулгах, хураах, түр хадгалах, ачих, түгээн хүргэх үйл ажиллагаанд энэхүү зааврын 5 дахь хэсэгт заасныг баримтална.

Зургаа. Тайлагналт

- 6.1 “Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо” нь “Тээврийн удирдлагын нэгдсэн систем” /www.teeverzuuch.mn/-д бүртгэгдэж, тээвэрлэгдсэн өвлийн идэшний тоо хэмжээ, тээвэрлэлтийн төлөвийн талаарх мэдээллийг өдөр бүр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус ирүүлнэ.
- 6.2 “Улаанбаатар импекс” ХХК, “МБҮ трейд” ХХК, “Монгол шуудан” ХК нь түр хадгалах агуулахаас хүлээн авагчид хүргүүлсэн өвлийн идэшний тоо хэмжээ, хэрэгжүүлсэн халдвар хамгааллын арга хэмжээний талаарх мэдээллийг өдөр бүр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус ирүүлнэ.

Долоо. Хяналт

- 7.1 Өвлийн идэш бэлтгэх, илгээх, тээвэрлэх, түр хадгалах агуулахад хүлээж авах, хадгалах, айл өрхөд түгээх үед хүнсний аюулгүй байдлыг хангах, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж буй эсэхэд аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар болон Мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

---000---